



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/Ч06

Мандалговь

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комиссыг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд шинээр баригдсан (бага, дунд, өндөр, онцгой төвөгшилтэй) барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтын 1-т заасан бүрэлдэхүүнтэй, барилга байгууламжийн гадна талбайн тохижилт, засварлах, тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг уг хавсралтын 2-т заасан бүрэлдэхүүнтэй тус тус байгуулсугай.

2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг холбогдох хууль, тогтоомж, дүрмийн дагуу чанартай зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Л.Доржбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210570